

IMPROVING MONGOLIA'S INVESTMENT CLIMATE AND ENHANCING ITS EFFICIENCY /A Comparative Study Based on Japan's Experience/

Dorjkhand Molomjamts^I, Takashi Nagatomi^{II}, Koichi Iwamoto^{III}

Abstract: Investment constitutes a fundamental driver of economic growth, productivity enhancement, and national competitiveness. It represents an essential component of development strategy not only for developing economies but also for advanced industrialized nations seeking to sustain long-term economic expansion. In particular, foreign direct investment (FDI) generates multifaceted benefits, including technology transfer, managerial innovation, employment creation, and the strengthening of export capacity. The investment climate is a comprehensive and multidimensional concept encompassing political stability, legal certainty, institutional capacity, policy coherence, and infrastructure development. This study examines selected political and legal factors affecting Mongolia's investment climate and undertakes a comparative analysis with Japan's experience. By identifying institutional strengths and policy practices that have contributed to Japan's investment environment, the paper seeks to propose practical and contextually appropriate measures for improving Mongolia's investment framework and enhancing the overall effectiveness of foreign direct investment.

Keywords: Foreign Investment, Investment Climate, Political Stability, Legal Environment

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

/Япон улсын туршлага, харьцуулсан судалгаа/

Хураангуй: Хөрөнгө оруулалт нь аливаа улсын эдийн засгийн өсөлт, бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйл бөгөөд зөвхөн хөгжиж буй төдийгүй хөгжлөөрөө тэргүүлэгч улс орнуудын хувьд ч эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Хөрөнгө оруулалтын орчин нь улс төрийн тогтвортой байдал, хууль эрх зүйн тодорхой байдал, институцийн чадавхи, эдийн засгийн бодлогын уялдаа, дэд бүтцийн хөгжил зэрэг олон хүчин зүйлээс бүрдсэн цогц ойлголт юм. Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны улс төр, хууль эрх зүйн зарим асуудлыг Япон улсын туршлагатай харьцуулан авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын орчин, улс төрийн тогтвортой байдал, хууль эрх зүйн орчин

^I Business School, National University of Mongolia, (E-mail): molomjamts@num.edu.mn

^{II} Faculty of Political Science and Economics, Kokushikan University (E-mail): nagatomi@kokushikan.ac.jp

^{III} Faculty of Political Science and Economics, Kokushikan University (E-mail): iwamoto@kokushikan.ac.jp

ОРШИЛ

Хөгжиж байгаа эдийн засагтай манай улсын хувьд эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэж цаашдын өсөлтийг хангах зайлшгүй нөхцөл бол орчин үеийн технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэчлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм. Хөрөнгө оруулалт нь аливаа улсын эдийн засгийн өсөлтөнд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь:

- Өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн үйл явцыг дэмжих;
- Шинжлэх ухаан технологийн дэвшлийг хурдасгах, инновацийг хэрэгжүүлэх /ажиллаж байгаа үйлдвэрийн техникийн шинэчлэн тоноглолт ба сайжруулалт, үйлдвэрийн үндсэн фондыг шинэчлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх гэх мэт/;
- Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах ба түүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үйлдвэрлэн гаргаж байгаа бүтээгдэхүүний нэр төрөл, зүйлийг шинэчлэх;
- Бүтээгдэхүүний борлуулалт ба үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, борлуулалтын ашиг, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх үндэслэл болж өгдөг.

Хөрөнгө оруулалтгүйгээр улс орон хөгжиж, төсвийн орлого бүрдэх боломжгүй. Иймд бид хөрөнгө оруулалтын асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн судалж, улмаар судалгаанд тулгуурласан бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар үр дүнд хүрэх нь тодорхой.

Дэлхийн геополитик, улс төр, эдийн засагт томоохон гүрнүүдийн төр засгийн бодлого, шийдвэр асар их нөлөө үзүүлдэг. Сүүлийн үед олон улсад өрнөж буй үйл явдлууд нь эдийн засагт тодорхойгүй төлөв байдлыг бий болгож, улмаар эдийн засгийг тэтгэдэг чөлөөт худалдаанд саад тотгор учруулснаар дэлхийн эдийн засаг агшиж эхэлсэн. Ийм цаг үед улс орнууд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадны хөрөнгө оруулагчдад ээлтэй бодлого явуулах замаар өөрсдийн эдийн засгийг сөрж тэлэх оролдлого хийж байна.

Дэлхийн эдийн засгийн тодорхойгүй төлөв, агшиж байгаа чиг хандлага нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос ихээхэн хамааралтай манай улсад таагүй нөлөө үзүүлж байгаа юм. Энэ нь зэсээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт, үнийн савалгааны нөлөөгөөр төсвийн алдагдал өсөх, валютын ханшинд дарамт үзүүлэх, цөөн улсаас хамаарах экспортын хамаарал улам нэмэгдэх, дэлхийн ложистик нийлүүлэлтийн сүлжээний тасалдлын нөлөөгөөр импортын барааны үнийн өсөлт зэрэг олон хүчин зүйлээр илэрч байна. Түүнчлэн Монгол улсын эдийн засаг АНУ ба БНХАУ-ын өрсөлдөөний геополитикт илүү мэдрэмтгий болсноор хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй болж гадаадын хөрөнгө оруулалт буурч байна.

Иймээс манай улс гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. Хөрөнгө оруулалтын орчин, нөхцөл гэдэг нь тухайн улс орон, бүс нутагт хөрөнгө

оруулахад нөлөөлж буй улс төрийн тогтвортой байдал, хууль эрх зүйн тодорхой байдал, институцийн чадавхи, эдийн засгийн бодлогын уялдаа, дэд бүтцийн хөгжил болон бусад хүчин зүйлсийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл, энэ нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдын тухайн улс орон, бүс нутагт хөрөнгө оруулах эсэх талаар шийдвэр гаргахад голлон нөлөөлдөг цогц хүчин зүйлүүд юм.

Хөрөнгө оруулалтын орчин, нөхцөл гэсэн ойлголтод дараах хүчин зүйлсийг хамааруулан авч үзэж байна. Үүнд:

1. Эдийн засгийн хүчин зүйлс
 - Макро эдийн засгийн тогтвортой байдал
 - Инфляци, валютын ханш, зээлийн нөхцөл
 - Зах зээлийн багтаамж, хэрэглэгчдийн худалдан авах чадвар
2. Хууль эрх зүйн орчин
 - Хөрөнгө оруулалтыг хамгаалах хууль, журам
 - Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
 - Татварын бодлого, өмчийн эрхийн баталгаа
3. Улс төрийн орчин
 - Улс төрийн тогтвортой байдал
 - Засгийн газрын бодлого, гадаад хөрөнгө оруулалтад хандах хандлага
 - Авлига, ил тод байдлын түвшин
4. Нийгмийн хүчин зүйлс
 - Хөдөлмөрийн нөөц, ажиллах хүчний боловсрол, ур чадвар
 - Амьжиргааны түвшин, хөдөлмөрийн зардал
 - Нийгмийн тогтвортой байдал
5. Дэд бүтэц ба технологи
 - Тээвэр, ложистик, эрчим хүч, харилцаа холбоо
 - Технологийн дэвшил, инновацийн түвшин
6. Гадаад худалдаа ба зах зээлийн нээлттэй байдал
 - Импорт, экспортын бодлого
 - Гадаад худалдааны түншлэл, гэрээ хэлэлцээр зэргийг багтааж авч үздэг.

Хөрөнгө оруулалтын эдгээр орчин нөхцлийг төр засгийн удаан хугацааны тогтвортой бодлогоор дэмжиж тэнцвэртэйгээр, жигд анхаарч, хөгжүүлж, боловсронгуй болгосноор гадаадын хөрөнгө оруулалтыг татах, улмаар нэмэгдүүлэх боломж бололцоо жинхэнэ утгаар бүрдэж өргөжин тэлнэ. Бид энэхүү өгүүлэлд гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах эсэх талаарх шийдвэрт ихээхэн чухал нөлөө үзүүлдэг хууль эрх зүйн болон улс төрийн орчны талаар авч үзлээ.

1. Хууль эрх зүйн орчин:

Гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж, хөрөнгө оруулах эсэх талаар шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлдэг онцгой чухал хүчин зүйл бол тухайн улсын

хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин нөхцөл, гадны хөрөнгө оруулалтыг хамгаалахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтууд юм. ЭЗХАХБ-ын тайланд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах гол нөхцөл болдог хэмээн дурьдсан байна. (OECD, 2022).

Монгол Улсын хувьд 2011-2012 онуудад гадаадын хөрөнгө оруулалт өндөр байсан бөгөөд энэ үед жилд таван тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирж байсан. Энэ тоон үзүүлэлт 2016-2017 онуудад эрс буурсан бөгөөд сүүлийн жилүүдэд эргээд бага зэрэг өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2024 онд дөрвөн тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн. Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр манай улс эдийн засгаа тэлэх, экспортоо нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийг өргөтгөх боломжтой болно. Тиймээс цаашдаа манай улс хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг сайжруулж, бизнес эдийн засгийн индексийн үзүүлэлтийг нэмэгдүүлж, төрөөс хөрөнгө оруулагчидтай харилцах харилцаагаа сайжруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай болж байна.

Монгол Улсад эдийн засаг, бизнестэй холбоотой 200 гаруй хууль тогтоомж үйлчилж байгаагаас 40 гаруй хууль тогтоомж гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн орчин нөхцлийг зохицуулж байгаа гэсэн судалгаа байдаг. Эдгээр хууль тогтоомжуудын дийлэнх нь гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээж, чөдөр тушаа болж байгааг салбарын яам анхааралдаа авч гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэхээр Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэд "Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах" төвийг 2026.01.12-ны өдөр байгуулсан байна.

ЭЗХЯ-аас 2025.12.18-ны өдөр УИХ-д Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг өргөн барьсан бөгөөд энэхүү хуулийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэж батлах төлөвтэй байна. Уг хууль нь өмчийг хамгаалах, бизнесийн нэр хүндийг хамгаалах, төрийн зохицуулалтыг тодорхойлох анхдагч хууль болохын хувьд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнийг дагаад "Хөрөнгө оруулалтын тухай" хуульд өөрчлөлт оруулах, "Худалдааны хууль"-ийн төслийг УИХ-д өргөн барихаар бэлтгэж байгаа зэргээр хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин нөхцлийг сайжруулах тал дээр нилээд эрчимтэй ажиллаж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын Засгийн газраас төрийн хяналт шалгалтыг ойлгомжтой тодорхой болгох, шинэ түвшинд буюу аж ахуйн нэгжид зөвлөн тусалж, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэргээр 2026 оны хаврын чуулганаар эдийн засаг, бизнесийн орчинг хамгаалсан, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, хүнд суртлыг арилгасан хуулиудыг батлан гаргах, хэрэгжүүлж эхлэх тал дээр анхаарч ажиллаж байна.

Харин Япон улсад гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулахтай холбогдсон дараах хууль тогтоомжууд үйлчилж байна. Тухайлбал, Foreign Exchange and Foreign Trade Act, Financial Instruments and Exchange Act, Japanese Corporate Law, Гадаад валют ба

гадаад худалдааны хууль, Санхүүгийн хэрэгсэл ба арилжааны хууль, Японы компани байгуулах, хувьцаа, хувьцаа шилжүүлэлт, хувьцаа эзэмшигчийн эрх-үйл ажиллагаа буюу corporate governance-тэй холбоотой хууль, Компанийн тухай хууль, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль зэрэг хууль тогтоомжуудаар зохицуулж байна.

2. Улс төрийн орчин:

Гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс тухайн улс оронд хөрөнгө оруулах эсэх талаар шийдвэр гаргахад ихээхэн анхаарч үздэг нэг чухал асуудал бол тухайн улс орны улс төрийн тогтвортой байдал юм. Засгийн газар нь ойр ойрхон солигддог, солигдох бүрт бодлого шийдвэр нь өөрчлөгддөг, авилга хээл хахуульд идэгдсэн төр засагтай байх нь гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээх маш том шалтгаан юм.

Монгол улс ардчилал, зах зээлийн нээлттэй эдийн засагт шилжиж эхэлсэн 1990 оноос /1990.03.21-нд ерөнхий сайдаар томилогдсон Ш.Гунгаадоржоос хойш 2026.03.30-нд ерөнхий сайдаар томилогдсон Н.Учрал хүртэл/ 2026 он хүртэл 36 жилийн хугацаанд нийт 19 ерөнхий сайд солигдсон бөгөөд /энэ дунд нэг ерөнхий сайд 2 удаа сонгогдсон/ нэг Засгийн газар дунджаар 1.9 орчим жил ажилласан байна. Ингэж ойр ойрхон Засгийн газар солигдсоноор гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой төр засгийн бодлого, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, өмнөх Засгийн газрын шийдвэрүүдийг цуцлах, хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах гэх мэтээр бодлогын залгамж шинж чанар алдагдах нь гадаадын хөрөнгө оруулагчдыг тодорхойгүй, эргэлзээтэй байдалд оруулж, тэдний итгэлийг алдах шалтгаан болж байна. Монгол улс зах зээлд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хойшхи Засгийн газруудын эдийн засгийн бодлого, гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримталсан бодлогуудыг тоймлон авч үзвэл дараах байдалтай байна.

Манай улс зах зээлд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хойшхи хугацаанд ажилласан засгийн газрууд бараг бүгд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадны хөрөнгө оруулагчдыг дэмжих, үүнтэй холбоотой хууль эрх зүйн орчин нөхцлийг тасралтгүй сайжруулах чиглэлд ихээхэн анхаарч ажиллаж ирсэн байдаг.

Ялангуяа Монгол улс зах зээлд шилжсэн эхэн үед хуучин ЗХУ болон социалист орнуудын зээл тусламж зогссоноор эдийн засгийн асар их хүндрэл бэрхшээлтэй тулгарч үүнийг даван туулахын тулд барууны орнууд, олон улсын байгууллага, хандивлагч орнууд, гадаад зах зээлд нээлттэй бодлого явуулж гадаадын зээл тусламж, томоохон хөрөнгө оруулалтыг татах чиглэлд онцгой анхаарч ажилласан. Тухайлбал, 1993 онд анх удаа “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийг батлан гаргаж, 1996 онд гадаадын хөрөнгө оруулалтын Зөвлөл, үүнийг өргөтгөн 1998 онд Гадаадын хөрөнгө оруулалт ба гадаад худалдааны агентлаг байгуулах зэргээр хууль эрх зүйн орчин, институцийг бүрдүүлж эхэлсэн явдал юм. Гэсэн хэдий ч өнгөрсөн хугацаанд

гадаадын хөрөнгө оруулалтыг хангалттай хэмжээнд татаж чадаагүй, зарим жил гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буцаад буурах зэргээр тогтвортой өсөлтгүй, уул уурхайн томоохон төслүүдийн гэрээ хэлцэл байнгын маргаан, асуудал дагуулж ирсэн зэрэг нь бид гадаадын хөрөнгө оруулалтыг татаж улс орны эдийн засгийн хөгжлийн чухал хөшүүрэг болгох асуудал дээр хангалттай үр дүнд хүрч чадаагүйг харуулж байна.

Бид өнгөрсөн хугацааны үйл ажиллагаанд бодит дүгнэлт хийж, алдаа оноог дэнслэн улс төрийн биш, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого шийдвэр боловсруулах шаардлагатай бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг татах тухай асуудал нь аль нэг засгийн газрын уриа лоозон биш, Монгол төрийн урт хугацааны тогтвортой бодлого болж хэрэгжих ёстой юм.

Улс төрийн орчин нөхцөлтэй шууд холбоотой өөр нэг чухал асуудал бол авилгын асуудал юм. Манай улс авилгын индексийг тодорхойлдог олон улсын байгууллагуудын үнэлгээгээр маш доогуур оноо авч байгаа нь Төрийн бүх шатанд авилга хээл, хахууль газар авсан, түүнтэй холбоотой хууль тогтоомжийн үйлчлэл, хэрэгжилт сул байгааг харуулж төр засагт итгэх итгэлийг бууруулж байна.

Авилгын индексээр хэмждэг гол асуудлууд нь:

- хээл хахууль,
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа эсэх,
- төрийн нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа эсэх,
- төрийн албаны томилгоо хэр шударга явагдаж байгаа эсэх,
- хэсэг бүлгүүдэд зориулсан хууль батлагдаж байгаа эсэх, өндөр албан тушаалтны авилгын хэргийг хэрхэн шийдвэрлэж буй байдал,
- авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт,
- шүгэл үлээгч болон мөрдөн байцаагч нарын эрх зүйн хамгааллын талаарх

асуудлууд ордог бөгөөд татварын гэмт хэрэг, хууль бус санхүүгийн гүйлгээ, авилгын оролцогч тал, мөнгө угаалт, далд эдийн засаг зэрэг асуудлуудыг хамааруулаагүй байдаг. Хэрэв эдгээр асуудлыг нэмж тусгавал манай улсын авилгын индекс одоо байгаагаас буурах магадлалтай гэж дүгнэж болно.

“Transparency International” Олон улсын байгууллага нь дэлхийн улс орнуудын авилгын түвшинг 1-100 хүртэл оноогоор дүгнэн жил бүр авилгын төсөөллийн индексийг (Corruption Perceptions Index, CPI) гаргаж байр эзлүүлдэг. Энэхүү оноо нь их байх тусам авилгын түвшин доогуур буюу “цэвэр” гэсэн ангилалд ордог бол оноо нь бага байх тусам авлига ихтэй, авлигад идэгдсэн орны тоонд ордог байна. Тус олон улсын байгууллагын хийсэн судалгаагаар 2025 оны байдлаар Монгол улс 100 онооноос 31 оноо авч авилгын түвшингээр дэлхийн 182 улсаас 124-рт эрэмбэлэгдэж байна. Монгол улсын авилгын төсөөллийн индексийг сүүлийн 10 жилээр харуулвал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1. Монгол улсын авлигын индекс /2016-2025 он/

	Он	Индекс
1.	2016	38
2.	2017	36
3.	2018	37
4.	2019	35
5.	2020	35
6.	2021	35
7.	2022	33
8.	2023	33
9.	2024	33
10.	2025	31

Эх сурвалж: <https://www.transparency.org/en/countries/mongolia>

Монгол улсын авлигын төсөөллийн индексийг авч үзвэл сүүлийн 10-аад жилд дунджаар 31-38 оноо авч авлигын түвшин маш өндөр буюу авлига ихтэй гэсэн ангилалд орж байна. Эндээс дүгнэж үзвэл Монгол улсын авлигын түвшин өндөр байгаа нь авлигын өндөр эрсдэлтэй, ардчилсан бус засаглалтай орон гэсэн ангилалд багтаж байгаа тул манай улсад гадаадын компаниуд хөрөнгө оруулахыг төдийлөн сонирхохгүй, болгоомжтой хандах нь тодорхой байна. Засгийн газрууд ойр ойрхон солигдож, солигдох тухай бүр албан тушаалтнууд солигдож хөрөнгө оруулалтын үргэлжилж буй өмнөх гэрээ хэлцлийг дахин авч үзэх явдал хэвийн үзэгдэл болсон.

Мөн үүний зэрэгцээ орон нутгийн иргэд болон янз бүрийн төрийн бус байгууллагын зүгээс санаатай болон санамсаргүй, зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүйгээр хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг гацаах, эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлэх, үүнд нь төр засгийн өндөр албан тушаалтнууд ямар нэг байдлаар оролцох зэрэг нь гадаадын хөрөнгө оруулагчдыг манай улсаас үргээх, тэдний итгэлийг сулруулах, олон улсад манай улсын нэр хүндийг унагаах буруу жишиг болон тогтоод удаж байна. 2026 оны 1-р сард /2026.01.30/ ХЗДХЯ-аас “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулж уг хуулийн төслийг УИХ-ын хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна. Мөн гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг шинэчлэн боловсруулж үүнтэй холбоотойгоор дагалдах олон хуулиудад зохих өөрчлөлтийг оруулахаар бэлтгэж байгаа зэрэг нь манай улсын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож авлигатай тэмцэх асуудлыг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой болох юм.

Тэгвэл Япон улсад бараг ижил цаг үед буюу 1991 оноос /Кийчи Миязава Япон улсын ерөнхий сайдаар 1991 оны 11-р сарын 05-ны өдөр томилогдсоноос хойш 2025 оны 10-р сарын 21-ний өдөр ерөнхий сайдаар томилогдсон Санаэ Такаичи/ 2025 он хүртэл 34 жилийн хугацаанд нийт 18 ерөнхий сайд солигдсон бөгөөд /энэ дунд нэг ерөнхий сайд 2 удаа сонгогдсон/ нэг Засгийн газар дунджаар 1.9 орчим жил ажилласан байна.

Сонирхолтой тохиолдлоор Монгол болон Япон улсуудад сүүлийн 34-35 жилийн хугацаанд 18 ерөнхий сайд солигдож Засгийн газрууд өөрчлөгдсөн нь маш төстэй адил байгаа хэдий ч Засгийн газруудын бодлогын залгамж чанар, энэхүү улс төрийн өөрчлөлтийн тухайн улс орны эдийн засгийн хөгжилд нөлөөлөх эерэг болон сөрөг нөлөөлөл нь харилцан адилгүй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Япон улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын талаарх бодлого нь манай улсаас нилээд өөр, өвөрмөц онцлогтой. Учир нь тус улс дэлхийн өндөр хөгжилтэй, тэргүүний техник технологитой улс учраас гадаадын бусад улс орнууд, бүс нутагууд руу ихээхэн хөрөнгө оруулалт хийж ирсэн, өөрөөр хэлбэл гадагш чиглэсэн хөрөнгө оруулалт нь давамгайлж ирсэн түүхтэй. Дэлхийн 2-р дайны дараа тус улс эдийн засгаа сэргээн босгох явцад гадаадын хөрөнгө оруулалтанд хатуу хяналт тавьж, маш хязгаарлагдмал хүрээнд гол төлөв технологи дамжуулах, лицензийн хэлбэрээр оруулж ирж байсан бөгөөд үүнийг гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж тооцоход учир дутагдалтай байв. (Parzycki & Fukao, 2008)

Харин 1967-1970 оны үеэс тус улс OECD-ийн *Capital Liberalization Code*-д нэгдэн орсноор гадаадын хөрөнгө оруулалт албан ёсоор орж эхэлсэн. Энэ үед тус улсын химийн үйлдвэр, автомашин, санхүүгийн салбар зэрэгт гадаадын компаниуд шууд хөрөнгө оруулж эхэлсэн гэж үздэг. Гэвч тус улс бусад өндөр хөгжилтэй улсуудыг бодвол удаан хугацааны туршид гадаадын хөрөнгө оруулалтанд ихээхэн болгоомжтой хандаж хязгаарлагдмал хүрээнд, хатуу хяналттай зохицуулж ирсэн. Тухайлбал, ерөнхий сайд Кичи Миязава, Морихиро Хосокава, Томичи Мураяма нарын засаглалын он жилүүд буюу 1991-1996 онуудад гадаадын хөрөнгө оруулалтын талаар тусгайлсан бодлого хэрэгжээгүй, өмнөх үеийн нэг адил хатуу хяналт, хязгаарлалтууд үргэлжилж байсан. Гэхдээ энэ үед гадаадын хөрөнгө оруулалт огт байгаагүй гэсэн үг биш. АНУ болон барууны өндөр хөгжилтэй орнуудын Coca cola, Philips, Bayer, Nestle, Shell, Ford, Louis Vuitton Malletier зэрэг үндэстэн дамнасан томоохон компаниудын хөрөнгө оруулалттай компаниуд үйл ажиллагаагаа явуулж байсан. Тухайлбал, 1992 оны байдлаар Япон улс дахь гадаадын хөрөнгө оруулалттай ТОП 25 компанийн 15 нь АНУ, 4 нь Англи, Франц, Герман, Канад, Нидерланд, Швейцари улсын тус бүр нэг компани үйл ажиллагаагаа явуулж байв. (Masson, 1995)

Харин 1996-1998 онуудад ерөнхий сайд Рютаро Хашимотогийн үеэс гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчныг аажмаар нээлттэй болгож эхэлсэн. Мөн үүний зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд амжилттай ажиллаж эхэлсэн. Улмаар 2001-2006 онуудад ерөнхий сайд Жүничиро Койзүмигийн шинэчлэлийн үеэс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эдийн засгийн сэргэлтийн аажмаар нээлттэй болж эхэлсэн бөгөөд 2012-2020 онуудад ерөнхий сайд Шинзо Абэгийн 2 дахь засаглалын үеэс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал хэрэгсэл хэмээн бодлогын төвд оруулж ирсэн байдаг. Үүний дараа 2020-2021 онуудад ерөнхий сайд Ёшихидэ Сугагийн засгийн газар өндөр технологи, дижитал салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах чиглэлд анхаарч ажилласан бол 2021-2024 онуудад ерөнхий сайд Фумио Кишидагийн Засгийн газар

хагас дамжуулагч, чипний үйлдвэрлэлд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад онцгой анхаарсан байдаг. 2023 оны эцсийн байдлаар Япон улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн 50.5 их наяд иенд хүрч, өмнөх оноос 9.3 хувиар өссөн бөгөөд энэ нь тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 8.5 хувийг эзэлж байна. (JETRO Investment Japan Report 2024)

2024-2025 онуудад ерөнхий сайд Шигэру Ишибагийн Засгийн газар инноваци, хиймэл оюун ухаан, ухаалаг эрчим хүчний салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад анхаарч ирсэн байна.

2025 онд шинээр сонгогдсон ерөнхий сайд Санаэ Такаичигийн Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтын талаарх өмнөх Засгийн газруудын бодлогыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ үндэсний эрх ашгийг хамгаалах тал дээр илүү анхаарал хандуулж байна. Үүнээс үзвэл Японы уламжлал, зан заншил, эдийн засгийн тогтолцоонд тулгуурласан уламжлалт бодлого аажмаар өөрчлөгдөхийн зэрэгцээ гадаад шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүнийг эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал арга хэрэгсэл болохын хувьд орчин үеийн өндөр технологийн салбаруудад түлхүү татах чиглэлд ихээхэн анхаарч байгаа нь харагдаж байна.

Тус улсад Засгийн газрууд ойр ойрхон солигддог хэдий ч бодлогын залгамж шинж чанар төдийлөн алдагдахгүй, улмаар хээл хахууль авлигын түвшин доогуур, эрх зүйн орчин нь боловсронгуй, амьдрах таатай орчин нөхцөл таатай, дэд бүтэц, харилцаа холбоо, тээвэр ложистикийн хувьд дэлхийд дээгүүрт орох хөгжилтэй зэрэг нь тус улсад гадаадын хөрөнгө оруулагчдыг татах таатай орчин нөхцлийг бүрдүүлж байдаг.

“Transparency International” Олон улсын байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн индексээр (Corruption Perceptions Index, CPI) 2025 оны байдлаар Япон улс авлигын түвшингээр 182 улсаас 18-рт эрэмбэлэгдэж байна. Япон улсын авлигын төсөөллийн индексийг сүүлийн 10 жилээр харуулвал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Япон улсын авлигын индекс /2016-2025 он/

	Он	Авлигын индекс
1.	2016	72
2.	2017	73
3.	2018	73
4.	2019	73
5.	2020	74
6.	2021	73
7.	2022	73

8.	2023	73
9.	2024	71
10.	2025	71

Эх сурвалж: <https://www.transparency.org/en/countries/japan>

Япон улсын авлигын төсөөллийн индексийг авч үзвэл сүүлийн 10-аад жилд дунджаар 71-74 оноо авч авлигын түвшин доогуур буюу цэвэр гэсэн ангилалд багтаж ирсэн байна. Энэ нь тус улс гадны хөрөнгө оруулагчдад эрсдэл багатай, үйл ажиллагаагаа шударгаар явуулах боломжтой гэсэн итгэлийг төрүүлж ингэснээр тус улсад орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх нэг чухал нөхцлийг бүрдүүлж байна.

Дүгнэлт

Бид хөрөнгө оруулалтын орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг цогц байдлаар Монгол болон Япон улсуудын онцлогийг харьцуулан судалсан бөгөөд энэхүү өгүүлэлд зөвхөн улс төрийн тогтвортой байдал, хууль эрх зүйн талын судалгааг товч авч үзсэн болно. Судалгаанаас үзвэл улс төрийн тогтвортой байдал нь гадаадын хөрөнгө оруулагчдын шийдвэрт чухал нөлөөтэй болох нь тодорхой бөгөөд засгийн газрууд ойр ойрхон солигдох нь гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээх гол шалтгаан биш харин үүнийг дагаад төр засгийн бодлого ойр ойрхон солигдох нь тэдний итгэлийг алдах, болгоомжлох нэг гол шалтгаан болж байна. Үүнийг Япон улсын жишээнээс харж болно. Япон улсад манай улсын нэг адил Засгийн газрууд ойр ойрхон солигддог хэдий ч гадаадын хөрөнгө оруулалтын талаарх бодлогын тууштай залгамж шинж чанар, авлигын түвшин ямагт маш доогуур байдаг зэрэг нь гадаадын хөрөнгө оруулалтын тогтвортой өсөлтөнд эерэгээр нөлөөлж байна. Тиймээс улс төрийн тогтвортой байдлыг хангах гэсэн ойлголтонд удаан хугацааны турш дахь төр засгийн бодлогын тогтвортой байдал, мөн төр засгийн бүхий л түвшин дэх авлига, хээл хахуулийг эрс багасгах нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах чухал хүчин зүйл болж байна.

Нөгөө талаар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн иж бүрэн тогтолцоог бүрдүүлж түүнийг шударгаар сахин биелүүлэх явдал маш чухал. Шүүх засаглал, хуулийн байгууллагын зүгээс гадны хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, аливаа асуудлыг хуулийн хүрээнд шударгаар шийдвэрлэх зарчмыг тууштай баримтлах нь тэдний итгэлийг баталгаажуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Ашигласан материал

- E.Chen & P.Drysdale (1995) Corporate links and Foreign Direct Investment in Asia and the Pacific
- Mark Masson (1995) Japan's Low levels of inward direct investment: Causes, consequences and remedies
- Peter Drysdale & Luke Gower (1999) The Japanese Economy Part 2, Volume VII
Routledge Library of Modern Japan
- Ralph Paprzycki, Kyoji Fukao (2008) Foreign Direct Investment in Japan: Multinationals' Role in Growth and Globalization
- Takeo Hoshi (2018) Has Abenomics Succeeded in Raising Japan's Inward Foreign Direct Investment? Asian Economic Policy Review Vol 13, No1. 149-168
- JETRO Investment Japan Report 2023
- JETRO Investment Japan Report 2024
- JETRO Global Trend and Investment Report 2025
- OECD. (2022). Foreign Direct Investment Regulatory Restrictiveness Index. Paris: OECD Publishing.
- <https://www.transparency.org/en/countries/japan>
- <https://www.transparency.org/en/countries/mongolia>
- <https://mn.usembassy.gov/mn/2022-investment-climate-statement-mongolia-mn/>
- https://www.jetro.go.jp/ext_images/hungary/pdf/globaltradeandinvestmentreport2025.pdf#:~:text=The%20world%20confronts%20the%20rising,4.
- https://www.jetro.go.jp/en/invest/investment_environment/ijre/report2023/
- https://www.jetro.go.jp/en/invest/investment_environment/ijre/report2024/ch2/sec1.html